



Долоо хоног тутмын хэвлэл
2015 оны 06 дугаар сарын 19
№23 /884/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1102

**Монгол Улсын Засгийн
газар болон Японы Олон
улсын хамтын ажиллагааны
байгууллага хоорондын
Улаанбаатар хотын олон
улсын нисэх онгоцны шинэ
буудал барих төсөл /II/-ийн
зээлийн гэрээг соёрхон
батлах тухай**

Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг

1104

**Прокурорын ёс зүйн
зөвлөлийн ажиллах журам,
бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай**



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

267. Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хоорондын Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл /П/-ийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай 1102

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

268. Прокурорын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай Дугаар 84 1103
269. Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Дугаар 85 1104
270. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 86 1110
271. Элчин сайдыг тохоон томилох тухай Дугаар 87 1110
272. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 88 1111
273. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 89 1111
274. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 90 1112
275. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 91 1112
276. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 92 1113



277.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 93	1113
278.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 94	1114
279.	Элчин сайдыг тохоон томилох тухай	Дугаар 95	1114
280.	Элчин сайдыг тохоон томилох тухай	Дугаар 96	1115
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
281.	Ноолуурын салбарын эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх тухай	Дугаар 171	1115
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ			
282.	Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 10	1116
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ			
2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр		Улаанбаатар хот	
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ ШИНЭ БУУДАЛ БАРИХ ТӨСӨЛ /III/-ИЙН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ			
<p>1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хоорондын Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл /III/-ийн зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.</p>			
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА		З.ЭНХБОЛД	



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 84

Улаанбаатар
хот

Прокурорын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 264 дүгээр зарлигаар баталсан “Прокурорын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1, 2.3, 4.7 дахь заалтуудыг дор дурдсанаар тус тус өөрчилсүгэй.

1/ “2.1. Зөвлөл нь дарга, 6 гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн дарга нь Улсын Ерөнхий прокурорын орлогч байх бөгөөд түүний эзгүйд үүргийг нь Улсын Ерөнхий прокуророос эрх олгосон зөвлөлийн гишүүн түр орлон гүйцэтгэнэ.”;

2/ “2.3. Зөвлөл нь эрх зүйн өндөр мэдлэг, мэргэжлийн ур чадвар, дадлага туршлага бүхий прокуроруудаас бүрдэх бөгөөд Зөвлөлийн дарга нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан Улсын Ерөнхий прокурорын орлогч байна.”;

3/ “4.7. Энэ журмын 3.1.1-д заасан прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн төвшинг шалгаж, дүгнэх ажлыг явуулах хугацааг Улсын Ерөнхий прокурорын баталсан удирдамж, төлөвлөгөөгөөр зохицуулах ба 3.1.2-д заасан мэргэшлийн төвшинг шалгах, дүгнэх ажиллагааг тухайн асуудлаар өгсөн үүрэг, даалгавар, саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногт багтаан гүйцэтгэнэ.”

2. “Прокурорын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 258 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны
06 дугаар сарын 04-ний өдрийн 84 дүгээр
зарлигийн хавсралт

**ПРОКУРОРЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга:

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан Улсын Ерөнхий Прокурорын орлогч

Зөвлөлийн гишүүд:

- Улсын Ерөнхий Прокурорын газрын Тамгын газрын дарга;
- Мөн газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга;
- Мөн газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга;
- Мөн газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн дарга;
- Төв аймгийн Прокурор;
- Нийслэлийн Прокурорын орлогч;

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 85

Улаанбаатар
хот

**Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах
журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 42¹ дүгээр зүйлийн 42¹.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг нэгдүгээр, “Прокурорын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 263, 2011 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 17 дугаар зарлигуудыг тус тус хүчингүйд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны
06 дугаар сарын 04-ний өдрийн 85 дугаар
зарлигийн нэгдүгээр хавсралт

ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Прокурорын ёс зүйн зөвлөл /Цаашид «Зөвлөл» гэх/ нь прокуророос ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар явуулсан шалгалтын дүнг хэлэлцэж, сахилгын хариуцлага хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэгтэй ажиллана.

1.2.Зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, холбогдох бусад хууль, Прокурорын ёс зүйн дүрэм, Прокурорын сахилгын дүрэм, энэ журам болон тэдгээрт нийцүүлэн гаргасан Улсын Ерөнхий Прокурорын тушаал, түүгээр баталсан баримт бичгийг удирдлага болгон үйл ажиллагаагаа прокурорын байгууллагын хэмжээнд нэгдмэл байдлаар хэрэгжүүлнэ.

1.3.Улсын Ерөнхий Прокурор нь Зөвлөлийн бүрэлдэхүүний талаарх саналаа Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүнд тавигдах шалгуур

2.1.Зөвлөл нь дарга, 10 гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн дарга нь Улсын Ерөнхий Прокурорын орлогч байх бөгөөд түүний эзгүйд үүргийг нь Улсын Ерөнхий Прокуророос эрх олгосон зөвлөлийн гишүүн гүйцэтгэнэ.

2.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батална.

2.3.Улсын Ерөнхий Прокурор нь зөвлөлийн гишүүнээр 3 жил ажилласан прокурорыг цаашид зөвлөлд ажиллуулах эсэх асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулан шийдвэрлүүлнэ.

2.4.Зөвлөл нь мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй прокуроруудаас бүрдэнэ.

2.5.Зөвлөл нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд түүнийг Улсын Ерөнхий Прокурор томилно.

2.6.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь прокурор байна.



2.7.Прокурор ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаарх шалгалтыг Улсын Ерөнхий Прокурорын газрын дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий зохион байгуулалтын бүтцийн нэгж хариуцаж явуулна.

Гурав. Зөвлөлийн эрх хэмжээ, чиг үүрэг

3.1.Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1.Прокурорын үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар явуулсан шалгалтын дүнг хэлэлцэж, дүгнэлт гаргана.

3.2.Зөвлөлийн дарга нь гишүүний эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.2.1.Прокуророос ёс зүйн зөрчил гаргасан талаарх гомдол, хүсэлтийг хүлээн авч танилцан энэ журмын 2.7-д заасан чиг үүрэг бүхий нэгжид шилжүүлж шалгуулах;

3.2.2.Гомдол, хүсэлтийг харьяаллын дагуу өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;

3.2.3.Шалгалтын материалтай урьдчилан танилцаж нэмэлт шалгалт хийлгүүлэх;

3.2.4.Шалгалтын дүнг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэх;

3.2.5. Шалгалтын дүнг харгалзан шалгалтын материалыг харьяаллын дагуу шилжүүлэх;

3.2.6. Зөвлөлийн хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангуулах, хуралдааныг удирдах, зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэр, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүргийг зөвлөлийн гишүүдэд даалгах, боловсруулсан төслийг хянан үзэх;

3.2.7.Зөвлөлийн хуралдаанаас гаргасан дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулах, гомдол, хүсэлт гаргагчид хариу өгөх;

3.3.Зөвлөлийн гишүүн дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.3.1.Прокурорын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг шалгасан дүнг хэлэлцэх зөвлөлийн хуралдаанд оролцох;



3.3.2. Үүрэгт ажилтай нь холбогдуулж өөрт нь илэрхий болсон, эсхүл итгэмжлэн мэдэгдсэн нууцыг чанд хадгалах;

3.3.3. Зөвлөлийн хуралдаанд тухайн прокурор ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар саналаа хэлэх;

3.3.4. Зөвлөлийн даргын даалгасан ажлыг хариуцах;

3.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах үүргийг хүлээнэ.

3.4.1. Зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах;

3.4.2. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтлөх;

3.4.3. Шалгалтын материалыг эмхэлж архивын нэгж болгох;

3.4.4. Бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.5. Гомдол, хүсэлтийг шалгах үүрэг хүлээсэн прокурор нь дараах тохиолдолд хянан шалгах ажиллагааг явуулахгүй байна.

3.5.1. Өөрөө гомдол, хүсэлтийг гаргасан болон прокурорын ёс зүйтэй холбоотой зөрчлийг илрүүлсэн бол;

3.5.2. Тухайн прокурортой, эсхүл гомдол, хүсэлт гаргасан этгээдийн гэр бүлийн гишүүдтэй төрөл, садан байвал;

3.5.3. Өөрөө шууд буюу шууд бусаар уг асуудалд хувийн сонирхолтой гэж үзэх үндэслэл байгаа бол;

Дөрөв. Гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаа

4.1. Прокурорын ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан гомдол, хүсэлт, түүнчлэн прокурорын газруудаас ирүүлсэн хүсэлтийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч зөвлөлийн даргад танилцуулна. Зөвлөлийн дарга тухайн гомдол, хүсэлтийг хүлээн авч шалгалт явуулах чиг үүрэг бүхий нэгжид шилжүүлнэ.

4.2. Гомдол, хүсэлтийг шалгах чиг үүрэг бүхий нэгж нь түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан шалгаж дуусгана. Нэмэлт ажиллагаа хийх шаардлагатай тохиолдолд зөвлөлийн дарга хугацааг нэг удаа 5 хүртэл хоногоор сунгана.



4.3. Шалгалт хийж буй прокурор нь Прокурорын байгууллагын тухай хууль, Прокурорын ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэх асуудлыг нарийвчлан шалган тогтоож, баримтжуулсан байна.

4.4. Прокурор ёс зүйн зөрчил гаргаснаа өөрөө хүлээн зөвшөөрч тайлбараа бичгээр гаргаж өгсөн тохиолдолд зөвлөл нь түүнд үндэслэн дүгнэлт гаргаж, Улсын Ерөнхий прокурорт танилцуулж шийдвэрлүүлэх бөгөөд энэ тохиолдолд энэ журмын 4.4-д заасны дагуу бусад баримтаар зөрчлийг баримтжуулан тогтоосон байна.

4.5. Шалгалтыг явуулахдаа албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс нотлох баримт шаардан гаргуулах, тайлбар авах, хавтаст хэргээс хуулбар хийх, шалгалтын материалыг тухайн прокурорт танилцуулж тэмдэглэл үйлдэх, хариу тайлбар авах зэрэг ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ.

4.6. Шалгалт явуулсан прокурор нь шалгалтын дүнгийн талаар танилцуулга бэлтгэж, зөвлөлийн хуралдаанд илтгэнэ.

4.7. Гомдол, хүсэлт гаргасан этгээд өөрийн биеэр хуралдаанд оролцох хүсэлтээ гаргавал зөвлөлийн хуралдаанд оролцуулж тайлбарыг сонсох ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирээгүй бол энэ нь Зөвлөлийн хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

4.8. Ёс зүйн зөрчилд холбогдон шалгагдаж байгаа прокурор хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд зөвлөлийн хуралдаанд оролцоно.

4.9. Зөвлөл нь прокурорын ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлыг хянан шалгасан шалгалт дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан хуралдаанаараа хэлэлцэнэ. Зөвлөлийн хуралдааныг нийт бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй хувийн ирцтэй хийнэ.

4.10. Зөвлөл шалгалтын дүнг хэлэлцээд олонхын саналаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

4.10.1. Прокурор ёс зүй зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргах;

4.10.2. Нэмэлт шалгалт хийлгэх;

4.10.3. Шалгалтын материалыг харьяаллаар шилжүүлэх;

4.11. Зөвлөлийн хуралдааны шийдвэр, зөвлөлийн дүгнэлтэд зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.



4.12.Санал хураалтад зөвлөлийн нарийн бичгийн дарга оролцохгүй ба санал хураалтын дүнг хуралдааны тэмдэглэлд тусгана. Хуралдааны тэмдэглэлд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна.

4.13.Зөвлөлийн дүгнэлтийг асуудал нь хэлэлцэгдсэн прокурорт мэдэгдэх ба энэ тухай баримт үйлдэж, шалгалтын материалд хавсаргана.

4.14.Зөвлөлийн дүгнэлтийг прокурор, гомдол, хүсэлт гаргасан этгээд нь эс зөвшөөрвөл түүнийг мэдэгдсэнээс хойш 3 хоногийн дотор зөвлөлийн даргад гомдол гаргаж болно.

4.15.Дээрх хугацаанд гомдол гаргаагүй бол уг хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэр, зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга нь Улсын Ерөнхий прокурорт тус тус танилцуулж шийдвэрлүүлнэ.

Тав. Бусад асуудал

5.1.Зөвлөлийн хуралдааны дэгийг Улсын Ерөнхий прокурор батална.

5.2.Зөвлөлийн бичиг хэрэг, техникийн бусад үйлчилгээг Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газар хариуцна.

5.3.Зөвлөл нь Улсын Ерөнхий прокурорын газрын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны
06 дугаар сарын 04-ний өдрийн 85 дугаар
зарлигийн хоёрдугаар хавсралт

ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

- Улсын Ерөнхий прокурорын орлогч

Зөвлөлийн гишүүд:

- Улсын Ерөнхий Прокурорын газрын Дүн шинжилгээ, судалгаа хяналт шалгалтын хэлтсийн дарга;
- Мөн газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга;
- Мөн газрын Сургалтын төвийн захирал;



- Мөн газрын Тамгын газрын орлогч дарга;
- Мөн газрын Гүйцэтгэх ажил хариуцсан прокурор;
- Мөн газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга;
- Тээврийн прокурор;
- Нийслэлийн Прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга;
- Дүүргийн 3 дугаар прокурорын газрын орлогч прокурор;
- Дүүргийн 4 дүгээр прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга;

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Равдангийн Болдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батлайн Чулуунхүүг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 87

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг тохоон
томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Дэлгэрмааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төмөрийн Лхагвадоржийг томилсуугай

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 89

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Одонжилийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулууны Баярмөнхийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Адъяагийн Ганбаатарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нэмэхийн Батааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Санжаасүрэнгийн Баярааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигийн Ганболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лодойдамбын Галбадрахыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Тайландын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чимиддоржийн Баттөмөрийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Тайландын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төмөрхүлэгийн Төгсбилгүүнийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгонбаярын Даваасамбууг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэдэндамбын Батбаярыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар
хот

Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Босни-Герцеговин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Монтенегро Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 5 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 171

Улаанбаатар
хот

Ноолуурын салбарын эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн банкны тухай хуулийн 8.1, Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2013 оны 126 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 141 дүгээр тогтоол, Засгийн газрын 2014 оны 165 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн хөрөнгөөс дамжуулан зээлээгүй үлдэгдэл, Засгийн газрын 2013 оны 256 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн нийлбэр дүнгээс 100.0 (нэг зуун) тэрбум төгрөгийн зээлийг ноолуурын салбарын үндэсний үйлдвэрлэгчдийн эргэлтийн хөрөнгийг дэмжих зорилгоор арилжааны банкуудаар дамжуулан олгох ажлыг зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д тус тус даалгасугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбатад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Ч.САЙХАНБИЛЭГ

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД

Д.ЭРДЭНЭБАТ



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2015 оны 6 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 12:00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа, Д.Сугар /илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Д.Цэрэнбадам оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсгийн “Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” Арван зургадугаар зүйлийн 4/ дэх хэсгийн “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Цэрэнбадам Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна:

“Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дунд суудлын хуралдаанаараа Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэхийг хянан хэлэлцэж 03 дугаар дүгнэлт гаргасныг бид бүхэн хүндэтгэн үзэж байна. Гэвч өнөөдөр нийгмийн харилцаа тэр дундаа банк, санхүүгийн салбарын хөгжил улам бүр хурдасч, Банкны тухай хуулийн энэ зохицуулалт өнөөдөр Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр



дүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтад нийцэхгүй болжээ.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт заасан “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд” гэдгийг тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын зарим тодорхойлолтоос харахад аливаа нэг арилжааны банкны 5 ба түүнээс дээш хувийн хувьцааг эзэмшигч иргэний гэр бүлийн гишүүд, төрөл садангийн бүхий л хүн, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудын гэр бүлийн гишүүд, төрөл садангийн хүмүүс, түүнчлэн Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд өөр банкинд хувь эзэмших эрхгүй болж хэт өргөн хүрээнд тодорхойлсон байна.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг Үндсэн хуулийн дараах зүйл, заалтыг зөрчсөн гэж үзэж байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хүн ажил, мэргэжил эрхлэх, албан тушаал хаших болон хувийн бизнесээ аливаа хязгаарлалтгүйгээр чөлөөтэй сонгон эрхэлнэ. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт заасны дагуу нэг банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч иргэний гэр бүлийн гишүүн, цаашилбал төрөл садангийн хүн нөгөө банканд удирдах албан тушаал хаших тохиолдолд энэхүү хоёр банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь өөр хоорондоо холбогдох этгээд болж байна. Улмаар нөгөө банкны эрх бүхий албан тушаалтан нь Банкны тухай хуулийн дагуу өөрийн албан тушаалаас татгалзах эсхүл 2 нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хэн нэгний эзэмшлийн хувьцааг бууруулах хууль зүйн үндэслэлтэй байна. Аль нэг банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн төрөл садан болж төрсөн нь тус этгээдэд Үндсэн хуулиар олгогдсон ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй юм.

2. Хууль санаачлагчид Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсгийг батлахдаа Олон Улсын Банкны хяналтын Базелийн хорооноос 2006 оны 10 дугаар сард баталсан Банкны үр дүнтэй хяналтын үндсэн зарчмын 4-т “Их хэмжээний хувьцааг шилжүүлэх: хяналт тавих эрх бүхий байгууллага нь банкинд дахь их хэмжээний хувьцааг бусдад шилжүүлэх саналыг хянах, үүнийг хүлээн авахаас татгалзах эрхтэй.” гэж боломжийг олгож, хориглосон хэм хэмжээ тусгаагүй байхад заавал биелэгдэх шинж чанартай хэм хэмжээ болгон хатууруулсан нь Монгол Улсын Үндсэн хуульд туссан иргэний өмчлөх эрхийн үзэл баримтлалтай эрс зөрчилдөж байна.



... яригдаж буй Олон улсын зарчимтай холбоотойгоор Монгол Улс нь ямар нэгэн хорооны гишүүнчлэлгүй, олон улсын гэрээ, контрактыг соёрхон батлаагүй байна.

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасанаар хүний эрх нь бусдын эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал болон нийгмийн зайлшгүй шаардлагаар хязгаарлагдах бөгөөд ийм шаардлагад тулгуурлаагүй хязгаарлалт нь өөрөө хүний эрхийг зөрчиж байна.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн дагуу Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянаж, дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл Үндсэн хуулийн цэцэд дараах агуулга бүхий тайлбарыг ирүүлжээ. Үүнд:

Нэг. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсгийн агуулгын талаар

Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үүднээс Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтад “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээдийг ойлгоно хэмээн хуульчлан тодорхойлсон төдийгүй мөн хуулийн 36 дугаар зүйлд аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, тэдний хувьцааны хэмжээ бүтцэд өөрчлөлт орохоор бол тухайн банк Монголбанкинд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах, түүнчлэн банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч өөр банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хоригложээ.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийн хүрээнд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч өөр банкны хувьцаа эзэмших босгыг тогтоож, өмчлөх эрхийг хязгаарласан нь дараах учир шалтгаантай юм. Үүнд:

1/ Банкны хяналт шалгалтын Базелийн хорооны “Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим”-д туссан Банкны хянан зохицуулах байгууллага, хянан шалгагч нь банкны нөлөө бүхий хувьцаа



эзэмшигчийг тодорхойлох, банкны хувьцаа эзэмших зөвшөөрлийг олгох, хязгаарлалт хийх зарчмыг Монгол Улсын хуульд баталгаажуулан тусгаж, банкны системийг тогтвортой найдвартай байдлыг хамгаалах, банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс учруулж болзошгүй эрсдэлийг бууруулах, хямрал, эрсдэлд өртөхгүй дархлааг бий болгох.

2/ Банкны бодлогыг тодорхойлж, голлох шийдвэр гаргадаг нэг банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид хэд хэдэн банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон тохиолдолд тэд хуйвалдан, өөрсдийн эрх ашигт нийцүүлэн шийдвэр гаргаж, банкны мөнгөн хөрөнгийг үрэгдүүлэх, завших, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журмыг зөрчих зэргээр банкинд хохирол учруулж, мөнгөн хадгаламж эзэмшигч болон харилцагч иргэн, хуулийн этгээдийн эрхийг зөрчиж болзошгүй, түүнчлэн нэг банкинд үүссэн эрсдэл нөгөө банкинд тархах, нэг банкин дахь харилцагчийн итгэл алдагдсанаар нөгөө банкны харилцагчид мөнгөн хөрөнгөө татаж, хөрвөх чадварыг бууруулах, зэргэлдээ банкууд хооронд санхүүгийн үзүүлэлтийг эерэг харагдуулах гүйлгээ хийх, алдагдлыг нуун дарагдуулах, хуулиар тогтоосон хязгаарлалтыг зөрчих зэргээр эрсдэлийг дагуулж болзошгүй учраас харилцагчийн өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах.

3/ Банкны тогтолцоонд шударга өрсөлдөөн бий болгох, нэг этгээдийн хэт давамгайлал, хараат байдлаас зайлсхийх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, зах зээлд шинэ банк нэвтрэх боломжийг бүрдүүлэх, банкны хөрөнгийн чадавхийг нэмэгдүүлэх, банкны сайн засаглалыг хөгжүүлэх зэргээр банкныг өөрийг нь хамгаалсан юм. Тухайн банкны өөрийн хөрөнгө багассан тохиолдолд тухайн банкны хувьцаа эзэмшигч нэмж хөрөнгө оруулах санхүүгийн чадавхитай байх, бусад банкинд дарамт учирч болох эрсдэлийг тооцож, тодорхой хязгаарлалт тогтоох.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ..., эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтын талаар:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байх зарчмыг тунхаглаж, үүний баталгаа болгон эрх, үүрэг хариуцлагыг тогтооходоо, шүүх хуулийг хэрэглэхдээ хүнийг ялгаварлан гадуурхаж болохгүй шалгуурыг нэрлэн заажээ.



Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтад ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх эрхийг ямар ч ялгаварлалгүйгээр нь адил тэгш олгосон бөгөөд харин уг эрхийг хүн бүр өөрийн үзэмжээрээ өөр өөр аргаар сонгон хэрэгжүүлэх эрхийг банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг хөнддөөгүй гэж үзэж байна.

Хууль тогтоогч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангах зарчмыг удирдлага болгож, Тавдугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийнхээ дагуу нэг талаас бусдын мөнгөн хөрөнгийг их хэмжээгээр хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж, ашиг олох банкны ашиг сонирхол, нөгөө талаас мөнгөн хөрөнгөө хадгалуулж, хүү авч, мөнгөн хөрөнгөө арвижуулах зорилго бүхий иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах, улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах хууль зүйн баталгааг бий болгох зорилгоор Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн өмчлөх эрхийг хязгаарлажээ.

Дээрх хязгаарлалт нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлан гадуурхах агуулгагүй байна.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.” гэсэн заалтын талаар:

Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх нь хөдөлмөрлөх эрхтэй холбоотой ойлголт юм. Иргэн хүн тодорхой мэргэжил сонгох нь чөлөөтэйгээр хөдөлмөрлөх буюу ажил, албаа сонгох угтвар нөхцөл юм. Иймд иргэд ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох нь хуулиар хориглоогүй аливаа ажил мэргэжлийг өөрийн хүсэл зоригийн дагуу эзэмших хууль зүйн боломж, харин хувийн аж ахуй эрхлэх нь иргэн хүн өөрийнхөө аж ахуйд хөдөлмөрлөж, материаллаг баялгийг бий болгон орлого олох хөдөлмөрлөх үйл ажиллагаа юм.

Иргэд аж ахуйн нэгж үүсгэн байгуулах хэлбэрээр хөдөлмөрлөх, цэргийн алба хаах, төрийн алба хаших, их дээд сургууль, коллежид суралцах, хувиараа эрхлэх аж ахуй эрхлэх, бусдын аж ахуйд хөлсөөр ажиллах, хүүхэд асран хүмүүжүүлэх, өрх гэрийн аж ахуй хөтлөх



зэрэг зорилготой, үр ашиг бүхий хөдөлмөрийг өөрийн сонголтоор эрхлэх боломжтой бөгөөд энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг саад болохгүй.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг нь компанийн сайн засаглалын зарчмуудыг баталгаажуулж, банкны эрсдэлийг бууруулах, итгэлцлийг бэхжүүлэх замаар банкны системийн тогтвортой байдлыг хангахаас гадна иргэн, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийг хамгаалсан хууль зүйн баталгааг бий болгосон тул Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг тус тус зөрчөөгүй байна. гэжээ.

Гурав. Монголбанкнаас Үндсэн хуулийн цэцэд дараах агуулга бүхий тайлбарыг ирүүлжээ.

1. Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.ж дэд заалтаар хууль тогтоогч нь холбогдох этгээдийг бие даан тодорхойлж болох эрхийг банкны хянан шалгагчийн хувьд Монголбанкинд олгосон зохицуулалт бөгөөд “Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.” гэдэгт чухам ямар этгээдийг хамааруулж болох талаар төрийн эрх бүхий байгууллага, Монголбанкнаас аливаа байдлаар хуулийн заалтыг нарийвчлан тодорхойлсон албан ёсны хэм хэмжээ тогтоосон акт одоогоор гараагүй байна.

Олон улсын “Банкны үр нөлөөтэй хяналт шалгалтын үндсэн зарчимд “Холбогдох этгээдийн гүйлгээ”-ний талаар “хянан шалгагч нь тухайн нөхцөл байдлаас холбогдох этгээдийн тодорхойлолтыг өөрийн үнэлэмжид тулгуурлан хэрэглэж болох”-оор заасан байдаг. Үүнийг гадаадын зарим улсад банкны хууль тогтоомждоо тодорхой зааж тусгасан байдаг. Тухайлбал, Канад Улсын “Банкны акт”-ын 11 дүгээр хэсэгт хянан шалгагч нь банкинд хяналт шалгалт хийх явцад аливаа этгээдийн хуульд заасан нөхцөл бүрдэж байвал тухайн банктай холбогдох этгээд гэж тооцох боломжтой байхаар заажээ.

Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн “3.1.2.ж. Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.” гэсэн заалт нь мөн хуулийн 3.1.2.а-3.1.2.ё дахь заалтад тодорхойлсон холбогдох этгээдэд хамаарахгүй боловч, Монголбанкнаас тухайлсан банкинд хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд тодорхой гүйлгээтэй холбоотойгоор шууд ба шууд бус хэлбэрээр банктай болон түүний холбогдох этгээдтэй тодорхой ашиг сонирхлын хувьд холбогддог, эсвэл ийм төрлийн харилцаанд



орсноор банкны шийдвэрт нөлөөлөх боломжтой этгээдийг тогтоож, хамруулах бүрэн эрхийг банкны хянан шалгагч буюу Монголбанкинд олгосон зохицуулалт юм.

Мөн тухайлсан банкнаас зээл авсан хоорондоо хамааралгүй хэд хэдэн хуулийн этгээдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны эцсийн зорилго нь банкны холбогдох этгээдийн үйл ажиллагаанд чиглэсэн / зээлийн хөрөнгийн нэг дансанд төвлөрүүлсэн/, эсвэл хоорондоо холбогдох этгээд болохгүй боловч тэдгээрийн эцсийн зорилго аливаа хэлбэрээр нэг этгээдэд /хуулийн этгээд үүсгэн байгуулах, хувь нийлүүлэх гэх мэт/ чиглэж байвал Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд тодорхойлсон нэг этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг тавих үүднээс тэдгээрийг холбогдох этгээд гэж тооцож болно.

Дүгнэж үзвэл Банкны тухай хуулийн “3.1.2.ж. Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.” гэсэн заалт нь олон улсын зарчимд бүрэн нийцсэн банкны хяналт шалгалтын амин чухал заалтын нэг юм.

2. Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн “3.1.2.д. тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн болон хянан шалгах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтан,” гэсэн заалтын “эрх бүхий албан тушаалтан” гэсэн нөхцлийг 2011 онд батлагдсан Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт “Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.” 84.2 дахь хэсэгт “Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна.” гэж тус тус заажээ.

Мөн тус хуулийн 20 дугаар зүйлд заасан банк байгуулахад бүрдүүлэх баримт бичигт 20.1.6 дахь заалтад Монголбанкнаас баталсан маягтын дагуу бүрдүүлж өгсөн банкны эрх бүхий албан тушаалтан, боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаарх тодорхойлолт багтаа бөгөөд уг заалтын “эрх бүхий албан тушаалтан” гэдэгт Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар баталсан “банкны зөвшөөрлийн журам”-ын 2.2.1 /банк байгуулах хүсэлтийн маяг/-д тодорхойлсон “Банкны бусад удирдах боловсон хүчинд – газар, хэлтэс, дотоод хяналтын болон бусад алба хороо, нэгжийн удирдлага” хамааруулж байна.



Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.д дэд заалтад заасан “эрх бүхий албан тушаалтан” гэдэгт Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2 дахь хэсэгт тодорхойлсон “... банкны албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээд” багтаж байна гээд энэ нь Үндсэн хуулийг зөрчсөн заалт биш гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Банкны салбарт өрсөлдөөнийг дэмжих, нэг буюу хэсэг этгээдийн хэт давамгайллаас зайлсхийх, шударга өрсөлдөөнийг дэмжих зорилгоор саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хязгаарласан нь банк, санхүүгийн тогтолцоонд хүлээн зөвшөөрөгдсөн банкны үр ашигтай хяналтын хэлбэр бөгөөд Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. ...” гэсэн хэсгийг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар дүгнэлтээр Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсгийн “Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.” гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3/ дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж шийдвэрлэсэн нь хүчин төгөлдөр байгаа болно.

3. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт заасан холбогдох этгээдийн талаарх иргэн Д.Цэрэнбадамын гаргасан мэдээлэл нь хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбогдсон асуудал байх бөгөөд тухайн асуудал Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС
ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт “Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. ...” гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Н. ЖАНЦАН

ГИШҮҮН

**Т.ЛХАГВАА
Д.СУГАР
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 14003